



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/23/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор Ж.Нямцэцэг
Утас: 98180022 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: “Мэдээлэл-Аудит” ХХК
Утас: 70159511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

Улаанбаатар хот
2021 он

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УБДС	Улаанбаатар дулаан сүлжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МНББХ	Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НШШГГ	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ХК	Хувьцаат компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
3.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	13
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.10. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа	14
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага гойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.БАЯНМӨНХ ТАНАА

2021.03.15 № 07/924
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛС	/төгрөгөөр/	
		2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	44,819,291.43	361,569,430.66
1.1.2	Дансны авлага	1,768,749,902.46	924,311,344.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,182,539.84	841,718.20
1.1.4	Бусад авлага	410,388.10	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,037,881,666.09	1,019,065,528.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	212,034,948.41	208,158,517.36
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,067,078,736.33	2,513,946,538.42
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	95,700,153,108.85	89,190,179,727.52
1.2.2	Биет бус хөрөнгө	13,100,201,579.75	13,106,424,478.23
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	340,642,513.57	427,907,323.31
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	109,140,997,202.17	102,724,511,529.06
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	112,208,075,938.50	105,238,458,067.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,462,080,339.47	1,862,543,932.98
2.1.1.2	Цалингийн өглөг	2,097,322.90	1,015,816.00
2.1.1.3	Татварын өр	213,721,855.08	308,465,744.77
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	125,070,350.46	115,537,900.58
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,802,969,867.91	2,287,563,394.33
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	904,511,275.72	1,288,166,169.02
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,135,344,502.01	1,015,034,448.83
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,039,855,777.73	2,303,200,617.85
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,842,825,645.64	4,590,764,012.18
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	109,934,367,286.40	109,934,367,286.40
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,496,116,697.19	2,496,116,697.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-17,071,083,290.73	-17,092,448,578.72
2.3.10	Хуримтлагдсан ашиг тайлант үеийн		-7,696,190,949.57
2.3.11	Эздийн өмчийн дүн	108,365,250,292.86	100,647,694,055.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	112,208,075,938.50	105,238,458,067.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	19,753,810,133.50	20,675,045,620.52
2	Борлуулалтын өртөг	24,098,985,714.54	26,001,206,661.94
3	Нийт ашиг (алдагдал)	-4,345,175,581.04	-5,326,161,041.42
4	Түрээсийн орлого	3,773,000.00	2,618,000.00
5	Хүүний орлого	59,202,801.14	42,756,995.74
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	152,393,970.13	291,576,200.51
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,960,702,855.16	1,849,566,251.28
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	265,021,063.66	273,725,520.79
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-18,877.00	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		283,023,549.06
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-6,355,548,605.59	-7,395,525,166.30
19	Орлогын татварын зардал	255,756,593.22	300,665,783.27
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-6,611,305,198.81	-7,696,190,949.57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-6,611,305,198.81	-7,696,190,949.57
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан


/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	-10,518,632,446.22	114,917,701,137.37
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				58,854,354.30	58,854,354.30
3	Залруулсан үлдэгдэл				-10,459,778,091.92	114,976,555,491.67
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-6,611,305,198.81	-6,611,305,198.81
5	Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт					0.00
7	Зарласан ногдол ашиг					0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0.00
9	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	-17,071,083,290.73	108,365,250,292.86
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-21,365,287.99	-21,365,287.99
11	Залруулсан үлдэгдэл				-17,092,448,578.72	108,343,885,004.87
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-7,696,190,949.57	-7,696,190,949.57
13	Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт					0.00
15	Зарласан ногдол ашиг					0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0.00
17	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	-24,788,639,528.29	100,647,694,055.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,914,566,186.07	23,881,858,244.68
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	22,844,872,561.80	23,706,657,028.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	69,693,624.27	175,201,216.68
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,904,953,849.50	22,321,123,407.30
	Ажиллагчдад төлсөн	2,917,822,700.15	2,917,302,992.07
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	949,150,293.44	954,859,522.34
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,143,952,534.49	9,831,475,835.68
	Ашиглалтын зардалд төлсөн	4,252,712,835.68	5,212,843,418.85
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,147,626,824.50	638,672,805.73
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	1,593,125,253.56	1,126,980,390.61
	Даатгалын төлбөрт төлсөн	1,387,206.00	
	Бусад мөнгөн зарлага	899,176,201.68	1,638,988,442.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,009,612,336.57	1,560,734,837.38
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	59,202,801.14	42,756,995.74
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	59,202,801.14	42,756,995.74
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,051,042,197.00	1,286,741,693.89
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,051,042,197.00	1,286,741,693.89
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-991,839,395.86	-1,243,984,698.15
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,772,940.71	316,750,139.23
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,046,350.72	44,819,291.43
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,819,291.43	361,569,430.66



2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая.төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	ДЭХ-ний үйлдвэрлэлт	мян.Гкал	729.4	788.9	761.6	-27.3	96.5
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	12.9	14.1	13.2	-0.9	93.6
	ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	716.5	774.8	748.4	-26.4	96.5
2	Нийт орлого	сая.төг	19,969.2	22,317.1	21,012.0	-1,305.1	94.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	19,753.8	22,114.1	20,675.0	-1,439.0	93.5
3	Нийт зардал	сая.төг	26,324.7	28,081.1	28,407.5	326.4	101.2
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	24,099.0	25,757.5	26,001.2	243.7	100.9
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	1,960.7	1,885.3	1,849.6	-35.7	98.1
	в) Хөрөнгө оруулалт их засвар	сая.төг	1,028.0	1,114.9	959.9	-155.0	86.1
4	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	-6,611.3	-5,764.0	-7,696.2	-1,932.2	133.5

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд мөнгөн хөрөнгийн данс, үндсэн хөрөнгийн данс, зардлын данс, дотоод хяналтын дансдын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, багийн ахлагч, ахлах аудитор Д.Товуудорж, аудитор Д.Туяа, аудитор Э.Отгонзаяа, шинжээч Ц.Отгонжаргал, шинжээч С.Наранцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон “Мэдээлэл-Аудит” ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01-08/59 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Амгалан дулааны станц” нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК гэсэн хариуцлагын хэлбэрээр бүртгэгдсэн байна. Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 71 дүгээр “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор батлагдсан “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн дүрмийн 1.4-т “Амгалан дулааны станц” ТӨХК нь 100.0 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 70.0 хувийг Эрчим хүчний яам, 30.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заажээ.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах ажил үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, “Амгалан дулааны станц” нь “ТЭЦ-4” ТӨХК-ийн охин компанийн статус нь өөрчлөгдөж ТӨХК болсонтой холбоотойгоор дотоод бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Байгууллагын дүрэм
- Бараа материал бэлтгэх, орлогод авах, зарлагадах журам
- Агуулахад бараа материал хүлээн авах журам
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам
- Кассын үйл ажиллагааны журам
- Эд хөрөнгийн тооллого явуулах журам
- Эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материал үнэ бүхий зүйлийн бүртгэл ашиглалт, хадгалалт хамгаалалтын журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

"Амгалан дулааны станц" ТӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд "Амгалан дулааны станц" ТӨХК-ний ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитортой хамтарч дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 1,260.8 сая төгрөгийн зөрчил илрүүлэн зөвлөмж өгч, хэрэгжүүлэн, хэрэгжилтийг хянаж ажилласан байна.

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "бага" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 26,580.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 531.6 сая төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардал 28,708.2 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцож 574.2 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,969.6 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	44.8	361.6	316.8
Авлага	1,772.3	925.2	-847.2
Урьдчилж төлсөн төлбөр тооцоо	212.0	208.2	-3.9
Бараа материал	1,037.9	1,019.1	-18.8
Үндсэн хөрөнгө	108,800.4	102,296.6	-6,503.8
Хойшлогдсон татварын хөрөнгө	340.6	427.9	87.3
Нийт хөрөнгийн дүн	112,208.1	105,238.5	-6,969.6
Өр төлбөр	3,842.8	4,590.8	748.0
Эздийн өмч	108,365.3	100,647.7	-7,717.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	112,208.1	105,238.5	-6,969.6

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 361.6 сая төгрөг болж 316.8 сая төгрөгөөр өссөн нь “УБДС” ТӨХК-аас авах дансны авлагын эргэн төлөлт удаашрах магадлалтай гэж үзэж 2021 оны 1 дүгээр сарын урьдчилгаа цалин олгоход зориулж өр төлбөрийн төлөлтийг хойшлуулж, харилцах дансанд үлдээсэн мөнгө байна.

Авлага дансны үлдэгдэл 925.2 сая төгрөг болж 847.2 сая төгрөгөөр буурсан нь “УБДС” ТӨХК-с авах авлагаа барагдуулснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн УБДС ТӨХК-аас авах нэмэлт усны авлага 0.4 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,019.1 сая төгрөг болж 18.8 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний нөөцийн үлдэгдэл өмнөх оноос 2,362 тонн буурснаас шалтгаалжээ.

Тайлант онд бараа материал нь худалдан авалтаар 10,783.6 сая төгрөг, үйлдвэрийн барилгыг барьсан гүйцэтгэгч компанийн үлдээсэн бүртгэлгүй байсан 52.8 сая төгрөгийн барааг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдэж, үйлдвэрлэлд 10,855.2 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 102,296.6 сая төгрөг болж 6,503.8 сая төгрөгөөр буурсан нь 1,219.7 сая төгрөгийн худалдан авалт хийж, ТӨБЗГ-ын 2020 оны 73 дугаар тогтоолоор 7.9 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Тоёото Хариер 78-07 УНИ машиныг Хил хамгаалах ерөнхий газарт, ТӨБЗГ-ын 2020 оны 01 тоот тогтоолоор 283.1 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй бульдозерыг “Багануур дулааны станц” ТӨХК-д балансаас баланст шилжүүлж, санхүүгийн программын тооцооллын алдаанаас шалтгаалан үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 21.1 сая төгрөгөөр илүү тайлагнагдсаныг залруулсан, тайлант жилийн 7,411.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 1,219.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1674 тоот зөвшөөрлийн дагуу 3.8 сая төгрөгийн үлдэгдэл өртөггүй хөрөнгийг акталсан байна.

Санхүүгийн тайлан болон татварын тооцооллын элэгдлийн зөрүүгээс шалтгаалан хойшлогдсон татварын хөрөнгө 87.3 сая төгрөгөөр өсөж, хойшлогдсон татварын өглөг 383.6 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 2,287.6 сая төгрөг болж 484.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 330.3 сая төгрөг нь нүүрсний төлбөр, 66.8 сая төгрөг нь цахилгааны төлбөр, 96.1 сая төгрөг нь татвар, НДШ-ийн өглөг, 0.9 сая нь бусад харилцагчдад төлөх өр төлбөрийн өсөлт, Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдсэн үндсэн хөрөнгийг орлогын аргаар бүртгэсэн бусад урт хугацаат өр төлбөрөөс тайлант онд шилжүүлэн бүртгэсэн бусад богино хугацаат өр төлбөр 9.5 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 2015-2016 онуудад Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдсэн үндсэн хөрөнгийг орлогын аргаар бүртгэснээс үүссэн 1,015.0 сая төгрөг, санхүүгийн тайлан, татварын зорилгоор байгуулсан элэгдлийн зөрүүгээс үүссэн 1,288.2 сая төгрөг, нийт 2,303.2 сая төгрөгийн өр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 100,647.7 сая төгрөг болж 7,717.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант жилд тайлант жилийн тарифт тусгагдаагүй элэгдлийн зардлын дүнгээр алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 232 дугаар тушаалаар 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 22,317.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 28,081.1 сая төгрөгөөр, алдагдлыг 5,764.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,024.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь элэгдлийн зардлын дүнгээр алдагдалтай ажиллах ба тайлант жилийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тарифт бүрэн тусгагдаагүйгээс шалтгаалсан байна.

Гүйцэтгэлээр 21,012.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,407.5 сая төгрөгийн зардал гарган, 7,696.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын эх үүсвэр нь дулааны эрчим хүч борлуулсны орлого, үйл ажиллагааны бус орлогод харилцах дансны хүүний орлого, үнс борлуулсны орлого, алдангийн орлого, цайны газрын түрээсийн орлого, хойшлогдсон орлогоос бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	сая.төг	19,969.2	22,317.1	21,012.0	-1,305.1	94.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	19,753.8	22,114.1	20,675.0	-1,439.0	93.5
2	Нийт зардал	сая.төг	26,324.7	28,081.1	28,407.5	326.4	101.1
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	24,099.0	25,757.5	26,001.2	243.7	100.9
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	1,960.7	1,885.3	1,849.6	-35.7	98.1
	в) Хөрөнгө оруулалт их засвар	сая.төг	1,028.0	1,114.9	959.9	-155.0	86.1
3	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	-6,611.3	-5,764.0	-7,696.2	-1,932.2	133.5

Нийт орлогын гүйцэтгэл 21,012.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,305.1 сая төгрөг буюу 5.8 хувиар тасарсан нь ДЭХ-ний түгээлт 26.4 мянган Гкал тасарснаас 724.4 сая төгрөгөөр, Эрчим хүчний зохицуулах хорооноос 2020 оны 4 дүгээр улиралд мөрдөх ДЭХ-ний тарифыг тодотгосон төлөвлөгөөтэй уялдуулан 1 Гкал тутамд 2744 төгрөгөөр бууруулж тогтоосноор 580.7 сая төгрөгөөр орлого буурсан зэрэг шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 28,407.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 326.4 сая төгрөг буюу 1.1 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Эрчим хүчний сайдын 2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн а/2732 тоот удирдамжийн дагуу 2020 оны батлагдсан нийт зардлыг Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, салбарын хэмжээнд тодорхой хүндрэлүүд үүсэж

байгаатай холбогдуулан их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлуудыг 5-аас доошгүй хувиар, бусад зардлыг 4-өөс доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч, нийт зардлыг 2.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 27,642.8 сая төгрөгийн зардалтай ажиллахаар тодотгосон бөгөөд төлөвлөгөөт зардлыг 772.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна. Үүнд:

- Түлшний зардал төлөвлөснөөс 240.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрчим хүчний зохицуулах хорооноос түлшний зардлын төлөвлөгөөг тодотгон батлахдаа нүүрсний газар дээрх үнийг илчлэгээс хамааруулан тооцоогүйгээс 135.3 сая төгрөг, төмөр замын таталт, тавилт, зам ашиглалтын зардлыг 55.7 сая төгрөг, уурхайнуудын нүүрсний харьцааг өөрчлөн алаг толгойн нүүрсийг 17 хувь зарцуулахаар тооцсоноос 49.6 сая төгрөгийн зардлыг дутуу тооцсон;
- Химийн бодис төлөвлөснөөс 41.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь техникийн баримт бичигт тусгагдсан тодорхой хугацааны давтамжтайгаар зайлшгүй хийх шаардлагатай дулааны шугамд шүүх бодисын зардлыг тодотгосон төлөвлөгөөгөөр хассан;
- Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 08-ний өдөр баталсан 18 дугаар тушаалаар батлагдсан зорилтот түвшинд тусгагдсан байсан урсгал засвар зуны сул зогсолтын хугацаанд хийгдсэн байхад Эрчим хүчний сайдын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 232 тоот тушаалаар зорилтот түвшнийг тодотгон батлахдаа урсгал засварын зардлыг хассан. Зун хийгдсэн урсгал засвар нь төлөвлөгөөний тодотгол хийгдэхээс өмнө гүйцэтгэсэн ажлууд учраас урсгал засварын зардал 288.6 сая төгрөгөөр хэтэрсэн;
- Эрчим хүчний зохицуулах хорооноос 2020 оны нийт зардлыг 2018 оны гүйцэтгэлийн хэмжээнд хянаж баталсан бөгөөд тус компани 2020 оны 2 дугаар сард ТӨХК болж өөрчлөгдсөнөөр компанийн Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаж, гишүүдийн цалин хөлс, ЭМНДШ-ийн зардлыг тооцож олгосон тул 55.0 сая төгрөг нэмэгдсэн;
- Ажиллагсдын нийгмийн зардал төлөвлөснөөс 99.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хамтын хэлэлцээрийн дагуу олгосон тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 57.7 сая төгрөгийн тэтгэмж, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цомхотголд орсон 2 ажилтанд 17.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон;
- Эрчим хүчний яам болон ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлснээр үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 281.5 сая төгрөгийн зардал зэрэг шалтгаанаар нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 41 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 959.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 7,696.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,932.2 сая төгрөгөөр илүү байгаа нь нийт орлого 5.8 хувиар дутуу биелсэн, зардал 1.2 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалж байна.

3.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 1, Эрчим хүчний яам 5, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 8 удаа зохион байгуулж 21 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой 1 журмыг шинээр боловсруулж, журмыг ТУЗ-ийн 2020 оны 11 тогтоолоор баталжээ.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд 55.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 53.9 сая, бусад зардалд 1.1 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага	1	110.1	1	110.1	100%
Зөвлөмж	5	11.7	4	11.7	80%
Нийт дүн	6	121.8	5	121.8	83%

Захиалагч, өмчлөгч, эзэмшигч, үнэлгээ нь тодорхойгүй Интернэшнл повер ХХК-ийн боловсруулсан үйлдвэрлэлийг Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх 50 Мт-аар өргөтгөх ТЭЗҮ байна. ТЭЗҮ-г боловсруулах талаар тухайн компанитай харилцан байгуулсан гэрээ байхгүй, ямар нэгэн төлбөр тооцоо төлөгдөөгүй байгаа нь хөрөнгө шамшигдах эрсдэлтэй тул холбогдох дээд байгууллагаар шийдвэр гаргуулж нягтлан бодох бүртгэлд тусгах зөвлөмжийг өмнөх оны аудитаар өгсөн бөгөөд тус зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ “0” өртгөөр бүртгэлд тусгасан байна. Энэ нь НББОУС-16 “Үндсэн хөрөнгө” стандарт зөрчигдөж байгаа тул хэрэгжүүлэх боломжгүй зөвлөмж гэж үзсэн тул зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай дүгнэгдэж байна.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,503.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 482.3 сая төгрөгийн алдааг залруулж, 10.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 127.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 883.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. Дүнг нягтлах

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. “Монгол ташуур констракшн” ХХК-тай хийсэн тооцоо нийлсэн актаас 1.3 сая төгрөгийн авлага илүү тайлагнасныг,
2. Санхүүгийн программын тооцооллын алдаанаас шалтгаалан үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 21.1 сая төгрөг, тайлант оны үндсэн хөрөнгө нь дэлгэрэнгүй бүртгэлээс 119.5 сая төгрөгийн зөрүүтэй, өмнөх оны аудитын залруулгаар үндсэн хөрөнгө данснаас урьдчилж төлсөн төлбөр дансанд бүртгэгдсэн 72.2 сая төгрөг залруулагдаагүй байсныг,
3. Дундаж өртгийн тооцооллын буруугаас тайлант оны шатахууны зардлыг 3.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг,

4. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 6.3 сая төгрөгөөр илүү тооцож, тайлагнасныг,
5. Хойшлогдсон татварын хөрөнгө 1.1 сая төгрөгөөр дутуу, хойшлогдсон татварын өглөг 141.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг,
6. Урт хугацаат өр төлбөрөөс тайлант үед төлөгдөх 115.5 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгээгүйг ангилал шилжүүлэн,
7. Цайны газрын түрээсийн орлогоос ТӨБЗГ-т төвлөрүүлэх орлогыг 0.5 сая төгрөгөөр дутуу тооцож, төвлөрүүлснийг нягтлан бодох бүртгэлд өглөг, авлагаар тусган тайлагнуулж тус тус залруулуулсан.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Байгууллагад ашиглагдаж байгаа зарим автомашинууд нь SMARTCAR.MN сайтад төлөгдөөгүй төлөвтэй 1,681,400 /нэг сая зургаан зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийн хуримтлагдсан торгуулийн өртэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. “Manage wall” ХХК-д ERP-8 санхүүгийн програмын сайжруулалт хийлгэхээр 3,600,000.00 /гурван сая зургаан зуун мянган/ төгрөг шилжүүлж, хэд хэдэн дансдын сайжруулалтыг хийсэн боловч уг програм нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага, удирдамж баталж, ажлын хэсэг байгуулах тухай” тушаалыг мөрдөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх” гэсэн заалтыг тус тус баримтлаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд шууд гэрээ байгуулан 90,000,000.00 /ерэн сая/ төгрөгийн өртөгтэй сэлбэг хэрэгсэл, 31,900,000.00 /гучин нэгэн сая есөн зуун мянган/ төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо, тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4. “Амгалан дулааны станц” ТӨХК нь 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр “Солид Юнит” ХХК-тай “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах” 10.0 сая төгрөгийн №124/2019 тоот гэрээ байгуулж, гүйцэтгэлийг акт үйлдэн хүлээн авсан боловч энэхүү нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг мөрдөлгүй гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Санхүү эрхэлсэн дэд захирлын боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдүүлэхээр баталсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.6 Зохицох зарчим алдагдсан, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”, Санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

**3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх
анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дараагын аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

НШШГГ-ын шийдвэргүйгээр Чингисийн хар алт ХХК-д шилжүүлэх 43.2 сая төгрөг, Багануур ХК-д шилжүүлэх 835.0 сая төгрөг буюу нийт 878.3 сая төгрөгийг харилцагч байгууллагаас өөр хамааралгүй компанийн дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх;
- Бусдад хөрөнгө завших боломж олгох
- Өмч, хөрөнгийн аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүргийн гүйцэтгэлийг хангаж ажиллах, үүрэг хүлээгээгүй хамааралгүй байгууллагатай гүйлгээ хийхгүй байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

2. Мөнгөн хөрөнгө данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сар бүрийн эцэс дэх кассын бэлэн мөнгөний үлдэгдэл 2.0 сая төгрөгөөс дээш байгаа бөгөөд буцааж харилцахад тушаасан гүйлгээ байхгүй байна. Энэ нь Амгалан ДЦС ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/16 тушаалаар батлагдсан "Кассын ажиллах журам" -ын 2.22-т "Кассын сар бүрийн эцэс дэх бэлэн мөнгөний хэмжээ 2.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Хэтэрвэл харилцахад тушаана" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, ангилал ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

- Бэлэн мөнгө шамшигдах, дүрэм журам хэрэгжихгүй байх;
- Санхүүгийн тайлангийн ангилал ба үнэлгээ батламж мэдэгдэл хангахгүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж

- Сар бүрийн эцэст байх бэлэн мөнгөний үлдэгдэлд хяналт тавьж, кассын ажиллах журмыг мөрдөж ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

2020 оны жилийн эцсийн байдлаар 56 нэр төрлийн өртгөө элэгдлээрээ бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай зөвшилцөж тогтоох" заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

- Хууль, журам хэрэгжихгүй байх;
- НББОУС-16 “Үндсэн хөрөнгө” стандарт мөрдөгдөхгүй байх;

3.3. Өгсөн зөвлөмж

- Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай зөвшилцөж шийдвэрлүүлэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

5 . Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Жолоочийн тооцооны хуудсаарх шатахуун зарцуулалтыг шалгахад 5.3 сая төгрөгийн шатахууныг нормоос хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад "жишиг нормыг шууд үндсэн норм болгон мөрдөж болох бөгөөд тодорхой хугацаанд шатахуун зарцуулалтын сорил, туршилтыг явуулсны үндсэн дээр бодит зарцуулалтад тулгуурлан үндсэн нормыг тогтоож мөрдөнө" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

- Хөрөнгийг үр ашиггүй зарцуулах;
- Сайдын тушаал, шийдвэр хэрэгжихгүй байх;

5.3 Өгсөн зөвлөмж

- Шатахуун зарцуулалтанд хяналт тавьж, норм нормативыг мөрдөж ажиллах;

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал
илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Амгалан дулааны станц ТӨХК –ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/28/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		Амгалан дулааны станц ТӨХК	Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	НШШГГ-ын шийдвэргүйгээр Чингисийн хар алт ХХК-д шилжүүлэх 43.2 сая төгрөг, Багануур ХК-д шилжүүлэх 835.0 сая төгрөг нийт 878.3 сая төгрөгийг харилцагч байгууллагаас өөр хамааралгүй компанийн дансанд шилжүүлсэн байна.	878.3	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
2	Сар бүрийн эцэс дэх кассын бэлэн мөнгөний үлдэгдэл 2.0 сая төгрөгөөс дээш байгаа бөгөөд буцааж харилцахад тушаасан гүйлгээ байхгүй байна.		Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Ч.Бямбаа
3	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаас өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 13.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 56 төрлийн хөрөнгө байна.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
4	НББ-д нь ашиглагдахгүй НБББББ-ийг Солид Юнит ХХК-аар 2019-12-13-ний өдрийн 124/2019 гэрээний дагуу 10.0 сая төгрөгөөр хийлгэж үр ашиггүй зардал гаргасан байна.	10.0	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
5	90.0 сая төгрөгийн өртөгтэй сэлбэг хэрэгсэл, 31.9 сая төгрөгийн багаж худалдан авалтыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн.	121.9	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
6	Байгууллагад ашиглагдаж байгаа автомашинууд нь 1.7 сая төгрөгийн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгууль бичигдсэн байна. Жолоочийн хариуцлагагүйн улмаас үүссэн өр төлбөрт хариуцлага ногдуулж зохих арга хэмжээ авагдаагүй байна. /SMARTCAR.MN цахим сайтаас/	1.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
7	Санхүүгийн программ сайжруулалт хийлгэхээр 3.6 сая төгрөг шилжүүлж, хэд хэдэн дансдын сайжруулалтыг хийсэн байгаа боловч "Manage wall" ХХК-ийн ERP-8 санхүүгийн программ нь СС-ын 2018 оны 47-р тушаалаар батлагдсан Санхүүгийн программ хангамжийн шаардлагыг хангаагүй байна.	3.6	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
8	Шатахууны нормыг мөрдөж ажиллаагүйгээс 5.4 сая төгрөгийн шатахууны зардал илүү зарцуулсан.	5.3	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх Ч.Бямбаа
ДҮН		1,020.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 дугаар сарын 15 № 84/АДТ0075
с.т. 0001/28/СТА-төлөг

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Амгалан дулааны станц" ТӨХК нь 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр "Солид Юнит" ХХК-тай "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах 10,000,000.00 төгрөгийн №124/2019 тоот гэрээ байгуулж, гүйцэтгэлийг акт үйлдэн хүлээн авсан боловч энэхүү нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг мөрдөлгүй гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Санхүү эрхэлсэн дэд захирлын боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдүүлэхээр баталсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.6-д "Зохицох зарчим", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", Санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 -т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 10,000,000.00 /арван сая/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, ерөнхий нягтлан бодогч Ч.Бямбаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.НЯМЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\031\Auditin 2-R Газар20.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 353/АД/70075

Улаанбаатар хот

СНТ- 0021/08/СТХ ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад ашиглагдаж байгаа зарим автомашинууд нь SMARTCAR.MN сайтад төлөгдөөгүй төлөвтэй 1,681,400 /нэг сая зургаан зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийн хуримтлагдсан торгуулийн өртэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад бүртгэлтэй, үйл ажиллагаандаа ашиглаж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой замын хөдөлгөөн зөрчсөн торгуулийг тухай бүр хянаж, буруутай этгээдээр төлүүлж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, ерөнхий нягтлан бодогч Ч.Бямбаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ж.НЯМЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 08 дугаар сарын 15

№ 354/АД 170075

Улаанбаатар хот

С.АТ-0021/28/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шууд гэрээ байгуулан 90,000,000.00 /ерэн сая/ төгрөгийн өртөгтэй сэлбэг хэрэгсэл, 31,900,000.00 /гучин нэгэн сая есөн зуун мянган/ төгрөгийн тонг төхөөрөмжийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4-д "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо, тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХА тухай хуулийг мөрдөж, хуульд заасан журмын дагуу тендер зохион байгуулж ажиллах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, ерөнхий нягтлан бодогч Ч.Бямбаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ж.НЯМЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ

01

001080469

САВАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 355/А0170075

Улаанбаатар хот

С.АТ- 2021/28/СТА-7041

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Manage wall" ХХК-д ERP-8 санхүүгийн програмын сайжруулалт хийлгэхээр 3,600,000.00 /гурван сая зургаан зуун мянган/ төгрөг шилжүүлж, хэд хэдэн дансдын сайжруулалтыг хийсэн боловч уг програм нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар "Нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага, удирдамж баталж, ажлын хэсэг байгуулах тухай"-аар батлагдсан санхүүгийн програмын шаардлагыг хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн програм хангамжийн сайжруулалтыг холбогдох шаардлагад нийцүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн захирал Ш.Баянмөнх, ерөнхий нягтлан бодогч Ч.Бямбаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ж.НЯМЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

"10.10.10.20.Bichig_Kherag_Alban_Shaardlaga"2021.0315auditin 2-R Газар130.Docx

001080460

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс